

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Гадаадын иргэн, харьяатын газар
2026 оны I улирал

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	
МУ-ын хууль						
1	16	33	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-12-31 Дугаар 2020.12.31	22.2. Энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 401.5. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 2/5924 дугаар албан бичгээр "Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх, нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй өвчний жагсаалт"-ын төсөлд санал авахаар ирүүлсний дагуу холбогдох саналыг боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/2308 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	50
2		34		Хууль зүй дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/98, А/25 дугаар хамтарсан тушаалаар "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журам"-ыг баталсныг мөрдөж байна.	100	
3	26	72	Аялал жуулчлалын тухай 2023-05-04 Дугаар 2023.05.04	18.5. Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Журам батлах тухай" 142 дугаар тогтоолоор "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан.	100
4		73		20.4. Үндэсний хорооны ажиллах журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн "Үндэсний хорооны ажиллах журам батлах тухай" 384 дүгээр тогтоолоор "Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны ажиллах журам"-ыг баталсан.	100
УИХ-ын тогтоол						
5	66	188	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасгай.	Гадаадын иргэн, харьяатын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх" арга хэмжээг тусган холбогдох журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар хянуулан баталсан.	50
УИХ-ын байнгын хорооны тогтоол						

6	95	313	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-11-01 Дугаар 2023_10 ЁЗСХБХ	1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх;	Тайлант хугацаанд байгууллагаас гаргасан аливаа шийдвэрийг төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн гаргаж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хариуцлагатай, шударга байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ тус дэд хорооны гишүүд нь Монгол Улсын Ёс зүйн дэд хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг"-ийг урьдчилан бөглөж, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжид заасан нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажилладаг болно.	100
7	97	315	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.1. Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 3, 6. 7. 8. 9 дэх дэд заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн болон монгол хүний ёс суртахууны түвшин, чиг хандлагыг тодорхойлох суурь судалгаа хийж, судалгаанд суурилсан бодлого боловсруулах;	Гадаадын иргэн, харьяатын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх" арга хэмжээ, Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах" арга хэмжээ, Төрийн албан хаагчийн 2026 оны сургалтын төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах" арга хэмжээг тус тус тусган баталсан. Түүнчлэн байгууллагын даргын 2024 оны А\454 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.1.1, 11.8, 11.10-т ёс зүйн хариуцлагатай холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжид заасан харилцааг хэрэгжүүлж байна.	100
8		316		1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн 2025 оны жилийн эцсийн тайланд үнэлгээ хийж мөн оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1643 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Түүнчлэн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг энэ оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр Ёс зүйн хороонд хүргүүлж ажиллалаа.	100

9	317		1.3. төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг өргөжүүлэх хүрээнд тайлант хугацаанд төрийн албан хаагчдыг чадавхжуулах болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах чиглэлээр нийт 2 удаагийн сургалт, арга хэмжээнд хичээл заасан байна. Байгууллагын даргын 2026 оны "Удирдах албан тушаалтны сургалт зохион байгуулах тухай" А/16 дугаар тушаалын дагуу удирдах албан тушаалтнуудын нэгдсэн цугларалтад 01 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд, "Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт зохион байгуулах тухай" 01-02/11 дугаар удирдамжийн дагуу шинээр томилогдсон албан хаагчдад 03 дугаар сарын 05-ны өдөр Ёс зүйн дэд хорооноос тус тус хичээл заалаа.	100	
10	351	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ТББХ	1.2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл болон гомдол, мэдээлэл, зөрчил, хариуцлагын нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулж, тогтмол хэрэглээнд хэвшүүлэх;	Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан 2026 оны 1 дүгээр улиралд байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн 2 гомдол мэдээллийг Төрийн албан зөвлөлийн цахим систем дэх "Монгол улсын Ес зүйн хороо" цонхонд бүртгэж оруулсан. Үүнээс 1 гомдлыг шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн ба 1 гомдол нь хянагдах шатанд байна.	100	
11	103		352	1.3.1. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2024 оны А/85 дугаар тушаалаар шинэчлэн 2024 оны "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн даргад урамшуулал олгох тухай" Б/116 дугаар тушаалын дагуу нарийн бичгийн даргад сар бүр, дарга, гишүүдэд улирал тутам урамшуулал олгож, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна.	100
12	353		2. тогтоолын хэрэгжилтийг ханган УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах хүрээнд байгууллагын "2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д 2 арга хэмжээг төлөвлөж 01 дүгээр сарын 05-ны өдөр, "Төрийн албан хаагчийн 2026 оны сургалтын төлөвлөгөө" болон "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-д тус тус 1 арга хэмжээг төлөвлөж 02 дугаар сарын 09-ний өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	50	
Ерөнхийлөгчийн зарлиг						
13	360		1.5. Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх	Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилж, 2021 оны 58 дугаар зарлигаар баталсны дагуу "Тэрбум мод" Үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх зорилгоор тус улсад оршин суух зөвшөөрөл хүссэн болон бүртгэл хийлгэж буй гадаадын иргэдэд мод тарих тухай зөвлөмж, мэдээллийг хүргэн байгууллагын цахим хуудсанд байршуулсан болно.	50	

14	106	361	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	<p>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.</p>	<p>"Тэрбум мод Үндэсний хөдөлгөөн" ТББ-аас 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан уулзалтад байгууллагын удирдлагууд оролцож, хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын байгаль орчныг хамгаалах, ой мод болон бэлчээрийн экосистемийг нөхөн сэргээх чиглэлээр гадаадын улс орнуудаас Монгол Улсыг зорин ирж буй иргэд, байгууллагуудын талаарх мэдээллийг харилцан солилцох, байгаль орчны салбарт олон улсын оролцоог нэмэгдүүлэх, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах талаар хэлэлцэв. Мөн байгууллагын даргын 01-02/15 дугаар удирдамжийн дагуу мод тарих үйл ажиллагаанд хамт олны идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор БНСУ-д төвтэй "Ногоон Ази" төрийн бус байгууллагатай хамтран "Мод тарих арга, технологи" сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, нийт 113 албан хаагчийг хамруулсан. Арга хэмжээний хүрээнд Ногоон Ази ТББ-тай хамтран 05 дугаар сард мод тарих ажлыг төлөвлөв. Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх зорилгоор мод тарихыг уриалсан постерийг 2023 оноос эхлэн байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтийг уриалж байна.</p>	100
15	109	364	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	<p>1. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг Гадаадын иргэн, харьяатын газар дэмжин хамтран ажиллаж байгаа болно. "Тэрбум мод Үндэсний хөдөлгөөн" ТББ-аас 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан уулзалтад байгууллагын удирдлагууд оролцож, хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын байгаль орчныг хамгаалах, ой мод болон бэлчээрийн экосистемийг нөхөн сэргээх чиглэлээр гадаадын улс орнуудаас Монгол Улсыг зорин ирж буй иргэд, байгууллагуудын талаарх мэдээллийг харилцан солилцох, байгаль орчны салбарт олон улсын оролцоог нэмэгдүүлэх, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах талаар хэлэлцлээ. Түүнчлэн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын даргын 01-02/15 дугаар удирдамжийн дагуу мод тарих үйл ажиллагаанд хамт олны идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор БНСУ-д төвтэй "Ногоон Ази" төрийн бус байгууллагатай хамтран "Мод тарих арга, технологи" сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, нийт 113 албан хаагчийг хамруулсан. Арга хэмжээний хүрээнд Ногоон Ази ТББ-тай хамтран 05 дугаар сард мод тарих ажлыг төлөвлөлөө. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд уриалга болгох зорилгоор постер байршуулсан.</p>	100
ЗГ-ын тогтоол						

16	117	387	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Тайлант хугацаанд байгууллагад холбогдуулан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээс гомдол бүртгэгдээгүй байна.	100
17	121	393	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах тухай 2025-03-26 Дугаар 2025_157	1. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй Хилийн Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төслийн ажлыг захиалагч тал "Тавантолгой төмөр зам" ХХК болон БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК хооронд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр гэрээ байгуулснаар эхлүүлсэн. Хаалттай бүсэд ажиллах хүч болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 210 иргэнд Монгол Улсын хилийн боомтоор нэвтрэх зохих ангилал, зориулалтын виз олгосон. Дээрх иргэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл С1 төрлийн оршин суух зөвшөөрөлтэйгээр тус төслийн хүрээнд гүүрийн барилгын ажлын хаалттай бүсийг байгуулж, хашаалж, камержуулсан ба оффис, ажилчдын кемп, хил, гаалийн хяналтын барилгын ажлыг гүйцэтгэн бараа материал, техник, тоног төхөөрөмж зөөвөрлөх, хадгалах зам, талбай, бетон узель, материал шинжилгээний лаборатори зэргийг барьж байгуулсан байна. Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 68 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгүүлэхээр "Хятадын төмөр замын барилгын корпорацийн гүүрэн барилгын товчоо групп монголиа" ГХОХХК-ны Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1280 иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.	100
18		394		2. Бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай тохиролцох яриа хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т даалгасугай.	Бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлаар хоёр улсын холбогдох байгууллагын яриа хэлэлцээрийн дүнд "түр журам" мөрдөхөөр тохиролцсон. Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд мөрдөх түр журам" батлагдсанаар Гадаадын иргэн, харьяатын газар тус журмыг мөрдөн ажиллаж байна.	100

19	123	396	Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204	1.1.4. аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улс-Хөвсгөл аймгийн Мөрөн сум чиглэлд олон улсын шууд нислэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж, нисэх буудлыг 4С ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг 2026 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар нарт, жуулчдыг саадгүй нэвтрүүлэх боломжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т.	Мөрөн Олон улсын нисэх буудалд "Чонжү-Мөрөн" чиглэлийн олон улсын шууд нислэг MR616, MLM616 дугаар агаарын хөлгүүдээр 2025 оны 07 дугаар сарын 29, 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд газардаж, эхний нислэгээр 2 улсын 98 гадаадын иргэн, хоёр дахь нислэгээр 1 улсын 94 иргэнийг тус тус хүлээн авч, хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд дахин нислэг үйлдэгдээгүй байна.	100
20	133	415	2027 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154	4. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2025 оны А/407 дугаар тушаалаар баталсан "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөр"-ийн 2.6, 2.7-д албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгайлан тусгасан. Монгол Улсад эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй бодлогод нийцүүлэн уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г жил бүр шинэчлэн баталж ажилладаг болно.	50
21	140	432	Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2025-12-24 Дугаар 2025_226	4. Энэхүү тогтоолыг албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, зайлшгүй шаардлагатайгаас бусад сул орон тоонд албан хаагч нөхөж авахгүй байх, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах зэрэг арга хэмжээ авах замаар 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Энэ тогтоолоор агентлагийн төрийн тусгай албан тушаалын цалинг шинэчлэн тогтоогоогүй тул Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагаанд хамаарахгүй болно.	Хэрэгжих боломжгүй
Ерөнхий сайдын захирамж						
22	152	445	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга	3.8. хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдэд хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал болон ёс зүйн алдаа гаргасан, эрх ашгийг нь хохироосон, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдсон төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад хариуцлага тооцох арга хэмжээг зохион байгуулах;	Тайлант хугацаанд байгууллагын даргын баталсан 2025 оны "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" А/440 дүгээр тушаал, мөн оны 02 дугаар албан даалгаварт заасныг зөрчсөн, хөндлөнгөөс оролцож нөлөөлсөн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтанд мэдэгдэх үүргээ хэрэгжүүлээгүй үндэслэлээр төрийн тусгай 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан.	100

23	446	хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64	7. Нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг арга хэмжээг бүх талаар дэмжиж, хяналт, хариуцлагаа сайжруулан, авлига, ашиг сонирхлын эсрэг “Шүгэл үлээгч”, “Шударга ёсны дуу хоолой” болж ажиллахыг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдэд уриалсугай.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Авлигад үгүй гэж хэлье”, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөж, шударга нийгмийг хамтдаа бүтээе”, “Авлигыг мэдээлэх утас 11-10” агуулга бүхий 3 постер, “Авлигад үгүй гэж хэлье” агуулгаар 1 рийл бэлтгэж, байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээ болон ep-e.mongolia.mn цахим системд тус тус байршуулж, сурталчиллаа.	100	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						
24	159	461	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэл 2024-09-18 Дугаар 2024_33	15.1.2.1. Үүнтэй холбогдуулан төрийн албан хаагчийг эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэл, халдлагад өртөх эрсдэлээс хамгаалах, аливаа асуудлыг хүч хэрэглэх болон хууль бус аргаар шийдвэрлэх зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хүлээлгэх хариуцлагыг чангатгах асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулах, энэ хүрээнд холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд даалгав	Уг тэмдэглэл нь "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зарим асуудлын талаар" хэлэлцсэн тайланд даалгавар өгөгдсөн тул Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүрэгт хамаарахгүй болно.	Хэрэгжих боломжгүй
25	172	481	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-12 Дугаар 2025_23	23.2.2.2. Говийн бүсийн байгаль, газар зүйн онцлогт түшиглэсэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аялал жуулчлалын маршрутыг батлах болон тухайн маршрутаар зорчих гадаадын иргэдэд Монгол Улсын хилээр нэвтрэх үнэмлэх олгох асуудлыг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар судалж, танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгав.”(2.2.“Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай”)	Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/3290 дүгээр албан бичигт дурдсанаар БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын яам, Гадаад хэргийн яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Гаалийн ерөнхий газраас хамтран “Хил орчмын аялал жуулчлалыг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж, мөн оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр заасан ба түүний хавсралтаар баталсан “Хил орчимд аялах хятад иргэдийн бүлэг жуулчдын нэрсийн жагсаалт”-ын загварыг хүргүүлэн энэхүү загвараар бүлэг жуулчид хил орчимд аялах бэлтгэл хангадсаныг мэдэгджээ. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д “Визийн загварыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” Монгол Улсын виз олгох журмын 6.7-д “Хил орчмын аялал жуулчлалаар ирэх бүлэг жуулчинд олгох “К3” ангиллын визийг ахлагчийн паспорт дээр, дагалдан зорчих гишүүдийн визийг жагсаалтаар буюу хавсралт хуудсаар олгож болно” гэж зохицуулсан тул жагсаалт хэлбэрээр олгох К3 ангиллын визийн загвартай холбогдох саналыг 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/1339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Загвар батлагдсан тохиолдолд “К3” ангиллын виз гэж үзэх боломжтой.	50

26	173	483	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-05-21 Дугаар 2025_24	24.35.7.1.2. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгжийн үйл ажиллагааны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ, тооцоо судалгаа хийж, харьяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн саналыг үндэслэн байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар”-т багтаан байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зарим нэгжийн чиг үүрэг, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлд чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор үндсэн чиг үүргийн бүтцийн нэгжийн орон тоог нэмэгдүүлэх, нэгж хооронд зарим чиг үүргийг шилжүүлэн иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний хүрээнд төсвийн зардлыг хязгаарлах, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой өөрчлөлт оруулах саналыг 2025 оны 01/656, 01/2066 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.	50
27	177	492	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09	5.1.5. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод.	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зорилгоор 2024 оноос эхлэн 53 төрлийн үйлчилгээг үе шаттайгаар цахимд шилжүүлсэн байна. Дээрх асуудлаар алдаа, зөрчил гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн сайд (Засгийн газрын гишүүн)-аас хариуцлага тооцуулсан албан тушаалтан байхгүй болно.	100
28	191	540	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-12-24 Дугаар 2025_34	33.8.2. 2.Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн хугацааг сунгах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт даалгав.	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тогтоолоор 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 178 дугаар тогтоолын 1 дэх заалтад өөрчлөлт оруулж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн.	100
29	194	549	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28 ний өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-28 Дугаар 2026_04	19.2.4. 4.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан хэрэгжүүлэх, Гадаадын иргэн, харьяатын газарт хамаарах арга хэмжээний хүрээнд 2026 онд төлөвлөгдсөн 4 ширхэг оршин суух үнэмлэх хэвлэх төхөөрөмжийг худалдан авах төлөвлөгөөнд тусгаж, тендер шалгаруулалтаар гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем (isf.mn)-д зорчигчийн мэдээллийн урьдчилсан хяналт хийх модулийг хөгжүүлэн, интеграци хийж, хоёр системийг холбох бүх нөхцөлийг бүрдүүлсэн.	100

30	196	557	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-11 Дугаар 2026_06	17.10.2.. 2.Өөрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний мэдээллийг "services.khurdan.gov.mn" цахим системд 2026 оны 04 дүгээр сард багтаан бүртгэх, цаашид төрийн үйлчилгээний мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь цахим системд бүртгэж хэвшихийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар болон төсвийн байгууллагуудын удирдлагад;	"Төрийн үйлчилгээний бүртгэл" нэгдсэн систем (services.khurdan.gov.mn)-д тус байгууллагын нийт 53 үйлчилгээ бүртгэгдсэнээс одоогийн байдлаар 50 үйлчилгээ цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Эдгээрээс 5 үйлчилгээг "e-mongolia.mn" системээр, 45 үйлчилгээг "isf.mn" системээр дамжуулан иргэдэд хүргэж байгаа бол бичиг баримт нягтлах, биет хяналт шалгалт хийх болон бусад байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай 3 үйлчилгээ (архивын баримтаас хуулбар олгох, хилийн боомтод цаасаар виз олгох, утсаар зөвлөгөө мэдээлэл өгөх)-г хиймэл оюунд суурилсан технологийн шийдлээр үе шаттай цахимжуулж байна.	50
31	197	563	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25 ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-25 Дугаар 2026_07	14.2. 2.Иргэд, олон нийтийн хэрэгцээ, шаардлагыг соргог мэдэрдэг, асуудал гарсны дараа бус гарахаас өмнө урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, ард иргэдээс хүсэн хүлээж байгаа хариуцлагатай төр, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, нийгмийн шударга ёсны зарчимд нийцсэн, тэдний оролцоог хангасан, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргахад идэвх, санаачилгатай, бодит үр дүнтэй ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Иргэд, олон нийтийн хэрэгцээ, шаардлагыг соргог мэдэрч, асуудал гарсны дараа бус гарахаас өмнө урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, ард иргэдээс хүсэн хүлээж байгаа хариуцлагатай төр, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, нийгмийн шударга ёсны зарчимд нийцсэн, тэдний оролцоог хангасан, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн шийдвэрийн хүрээнд үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, энэ оны 03 дугаар сард зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлсэн хиймэл оюун (AI)-д суурилсан чатботыг хөгжүүлснээр бүх улсын хэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх боломжтой болсон. Түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газарт ашиглагдаж байсан 20 утасны дугаарыг нэгтгэн, нэг гарцтай 75998282 дугаар бүхий бизнес утасны системийг нэвтрүүлж, иргэд олон дугаар руу залгах, холбогдохын тулд удаан хүлээх, мэдээллийг дутуу авах зэрэг хүндрэлүүдийг арилгалаа.	100
ЗГ-ын албан даалгавар						
32	198	573	Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах "Хариуцлагатай шуурхай алба" ажиглалтын тухай	3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд "Хариуцлагатай шуурхай алба"-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн "Хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай" А/94 дугаар тушаал батлан камерын хяналтаар болон биет байдлаар хяналт тавьж ажиллалаа. Мөн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд Монгол Улсын хууль тогтоомж болон улсын онц чухал объектод тогтоосон журмыг сахин биелүүлэх, объектын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 01, 02 дугаар зөвлөмжийг 02 дугаар сарын 09, 02 дугаар сарын 13-ны өдөр төв байгууллагын зохион байгуулалтын нэгжүүд, хилийн боомт, орон нутаг дахь газруудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан.	100

33	574	2026-02-11 Дугаар 2026_01	4.Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.	Сар шинийн баярын өдрүүдэд байгууллагын даргын 2026 оны А/94 дугаар тушаалын дагуу 02 дугаар сарын 17-ноос 23-ны өдрүүдэд төв байгууллага, хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсүүдэд хариуцлагатай эргүүл 1, жижүүр 1, шаардлагатай чиг үүргийн газар, хэлтсүүдэд нэмэлт 1 албан хаагчийг 24 цагийн хуваариар үүрэг гүйцэтгүүлж, 10:00, 14:00, 16.00 цагуудад нөхцөл байдлын мэдээг тухай бүр мэдээлж ажилласан. Дээрх хугацаанд аюул, осол, онцгой нөхцөл байдал бүртгэдээгүй.	100
34	581	Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай	1.1.1.. 1.1.3.Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг оновчилж, хүсэлт шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлэх;	Хүсэлт шийдвэрлэх үйл явцын ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор хэрэглэгчийн бүртгэлтэй цахим шуудан (e-mail)-аар дамжуулан шат бүрийн мэдээллийг хүргэх автоматжуулсан системийг нэвтрүүлсэн. Мөн энэ оны 02 дугаар сараас эхлэн иргэдэд үзүүлж буй цахим үйлчилгээний явцын талаар мэдээлэл өгөх, тодруулга авах зорилгоор байгууллагын нэгдсэн 75998282 дугаараас гадагш дуудлага хийх техникийн боломжийг бүрдүүллээ. Түүнчлэн иргэд, үйлчлүүлэгчдээс санал хүсэлт, мэдээлэл хүлээн авах 1800-1882 тусгай дугаарыг тогтмол ажиллуулж байна.	100
35	582		1.1.2.. 1.1.1.эрхлэх асуудлын хүрээнд ашиглаж байгаа мэдээллийн системийг мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем /system.gov.mn/-д бүртгэх;	Байгууллагын эрхлэх асуудлын хүрээний үндсэн системүүд болох eimmigration, evisa.mn, RNSF, isf.mn гэсэн 4 мэдээллийн системийг "Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем" (system.gov.mn)-д 2026 оны 01, 02 дугаар сард бүртгүүлж, "Үүссэн" төлөвт оруулсан.	100
36	583		1.1.3.. 1.1.3. төрийн байгууллага ашиглаж байгаа мэдээллийн системд гадаадын иргэнийг таньж, баталгаажуулан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	"ДАН" систем дэх гадаадын иргэнийг таньж баталгаажуулах модулийг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн сан" (isf.mn) системтэй холбож, өгөгдөл солилцох API болон серверийн тохиргоог гүйцэтгэсэн. Гадаадын иргэнд зориулсан "Хэрэглэгчийн хэсэг"-ийг хөгжүүлж, нэвтэрсэн хэрэглэгчид виз, оршин суух зөвшөөрөл болон бусад холбогдох мэдээллийг санхүүгийн болон бүртгэлийн мэдээллийн сангуудтай уялдуулан харах боломжийг бүрдүүллээ. Түүнчлэн систем хоорондын мэдээлэл дамжуулах урсгалыг шифрлэж, хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах техникийн туршилтуудыг амжилттай хийж, системийн нэвтрүүлэлтийн дараах тогтвортой ажиллагааг ханган ажилласан.	100
37	584		1.1.4.. 1.1.4.төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ийг ашиглах, ижил зорилготой мэдээллийн систем, гар утасны аппликейшныг тус системд нэгтгэх.	Байгууллагын албан ёсны цахим хуудас болох immigration.gov.mn хуудсыг "E-Mongolia" платформын "Төрийн байгууллага" цэсэд холбож, хэрэглэгчийн интерфэйс болон мэдээлэл солилцооны урсгалыг тохируулсан. Цаашид "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн сан" (isf.mn) цахим системийн мэдээлэл, үйлчилгээ цэсийн мэдээлэл солилцоог хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	50

2026-02-11
Дугаар 2026_02

38	585		1.2.1.. 1.2. Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр 1.2.1.Төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ системийг ашиглан төрийн байгууллага хооронд солилцох боломжтой мэдээллийг цаасан хэлбэрээр иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг харьяа байгууллагын хэмжээнд авах	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан №Ц/ХУР-2025/436, №Ц/ХУР-2025/436-97, Ц/ХУР-2025/436-102, №Ц/ХУР-2025/436-144 дугаар бүхий "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ээр Боловсролын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар гэсэн нийт 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" (isf.mn) системд холбох хөгжүүлэлтийг дуусган үйлчилгээнд нэвтрүүлсэн. Харин Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөний газар нь тухайн бүртгэлийн системээ гүйцэтгэгч байгууллагаас хүлээн аваагүй, нэмэлт сервис хөгжүүлэлт хийх боломжгүйгээс хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, Статистикийн хороонд гадаадын иргэний хаяг бүртгэх бүртгэлийн систем байхгүйгээс хаягийн тодорхойлолт, Гадаадын хөрөнгө оруулалтын газарт бүртгэлийн систем байхгүйгээс хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг isf.mn системд холбох боломжгүй байна. Мөн байгууллагаас 13 сервисээр 25 байгууллагад мэдээлэл хүргэж байна.	50	
39	586		1.2.2.. 1.2.2.иргэн, хуулийн этгээдээс цахим шуудангаар болон хуульд заасан бусад цахим хэлбэрээр илгээсэн, хүлээн авсан хаалттайгаас бусад мэдээлэл, баримт бичгийг цахим хэлбэрээр архивлах асуудлыг холбогдох стандартад тусгах арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;	Тус байгууллага нь Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ep.e-mongolia.mn) болон Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хэрэг хөтлөлтийн программ (edoc.mojha.gov.mn)-ыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлснээр албан хэрэг хөтлөлтийн бүх шат дамжлагыг цахимжуулж, баримт бичиг боловсруулах, илгээх, шийдвэрлэх үйл явцыг шуурхай болгосон. Эдгээр системийг ашиглан иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн цахим баримтыг нэгдсэн стандартаар хүлээн авч, архивын нэгж болгон баталгаажуулах замаар төрийн үйлчилгээний уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангаж байна.	100	
40	200	592	Онцгой нөхцөл байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай 2026-03-04 Дугаар 2026_03	2.2.. 2.2. Ажлын хариуцлага алдсан, холбогдох үндэслэл тооцоо, судалгааг муу хийж, алдаатай шийдвэр гаргасан албан тушаалтанд тухай бүр нь хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлж ажиллах;	Хаврын улиралд үүсэж болзошгүй байгаль, цаг агаарын хүндрэл, гамшиг, осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч ажиллах чиглэлээр хариуцлага алдсан, алдаатай шийдвэр гаргасан албан тушаалтан бүртгэгдээгүй болно.	100
Ерөнхий үнэлгээ 82.5 хувь						